



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 9/193

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагын аюултай
хог хаягдлыг зохицуулах заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.13, 8.1.15 дугаар заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн 8.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах журмыг нэгдүгээр, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зөөвөрлөх, түр хадгалах зааврыг хоёрдугаар, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн болон хэсгийн байгууламжид тавигдах шаардлагыг гуравдугаар, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг дөрөвдүгээр, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг бүртгэх, тээвэрлэх, устгасан тухай бүртгэлийн маягыг тавдугаар, Зоонозын шалтгаант халдварт өвчний үед мал, амьтны үхдэл, сэг, зэм устгах зааврыг зургаадугаар, хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвтөө тусгахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141251115

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 сарын 09-ны өдрийн 442 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явцад үүсэж байгаа эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюулгүй аргаар устгахтай холбоотой үйл ажиллагаа нь энэхүү журмаар зохицуулагдана.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг үүсгэж байгаа бүх эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтан, хог хаягдлын тээвэрлэлт, боловсруулалт, устгах үйл ажиллагаа эрхэлдэг Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллага энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Аймаг, сум, дүүрэг, хорооны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын үүрэг, оролцоо

2.1. Аймаг, сум, дүүрэг, хорооны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үүрэг, оролцоо

2.1.1 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулахад чиглэсэн орон нутгийн хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжийг бий болгох, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, хяналт тавих;

2.2. Аймаг, сум, дүүрэг, хорооны Засаг даргын үүрэг, оролцоо

2.2.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар аюултай хог хаягдлыг боловсруулах, хоёрдогч түүхий эдээр дахин ашиглах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүй аргаар устгах байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжих, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.2 Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд төсөл, хөтөлбөрийг дэмжих, төслийн санал гаргах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, удирдан, зохион байгуулах;

2.2.3 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

2.2.4 Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан эсхүл эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тархалтыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах.

Гурав. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

3.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийн бодлого чиглэлээ тодорхойлж, урт, богино хугацааны төлөвлөгөө, журам, заавар батлан, хэрэгжүүлэх талаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санал боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулахад салбар хоорондын байгууллагуудтай хамтран ажиллах, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.3. Болзошгүй гамшиг осол, цар тахал зэрэг нийгмийн эрүүл мэндэд ноцтой үйл явдлын үед аюултай хог хаягдлын зүй зохистой менежментийг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, нөөцийг бүрдүүлэх;

3.4. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментэд зарцуулагдах төсөв, зардлыг тооцох аргачлал, жишиг тарифыг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тодорхой давтамжтай шинэчлэн батлах, төсөвт тусгуулах;

3.5. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

3.6. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах, дахин ашиглах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

3.7. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, аюултай хог хаягдлын менежментийн өртөг зардал, үр ашгийн тооцоо судалгааг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж цаашид авах арга хэмжээг төлөвлөх.

Дөрөв. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн чиг, үүрэг

4.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүйгээр хангах мэргэжлийн төв байгууллагын үүргийг гүйцэтгэнэ;

4.2. Эрүүл мэндийн байгууллагуудад хог хаягдлын менежментийн үнэлгээ, тооцоо судалгаа хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргуулах;

4.3. Эрүүл мэндийн байгууллага, хог хаягдлыг боловсруулах, устгах байгууллага, аж ахуйн нэгжүүдээс сар тутам аюултай хог хаягдлын мэдээг төрөл тус бүрээр авч, тайлан гаргах;

4.4. Аюултай хог хаягдлын менежменттэй холбоотой байгууллага, аж ахуйн нэгж, эмч, мэргэжилтэнд мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, сургах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

4.5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийг сургах, бэлтгэх;

4.6. Хог хаягдлын менежментийн чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгуулах. Үүнд:

4.6.1. Хог хаягдлын менежментийн сургагч багш бэлтгэх;

4.6.2. Хог хаягдлын ажилтныг мэргэшүүлэх сургалт;

4.6.3. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдад зориулсан богино хугацааны сургалт.

4.7. Хог хаягдлын менежментийн сургалт хийж байгаа байгууллага, нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллах, сургалтын чанарт Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран хяналт, үнэлгээ хийх;

4.8. Аюултай хог хаягдлын менежментийн хэрэгжилт, аюултай хог хаягдлыг боловсруулах, устгахад ашиглаж байгаа тоног төхөөрөмж, устгалын арга, хүний нөөцийн бэлтгэгдсэн байдал, хангалт зэрэг эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл, судалгааг жил бүр авч үр дүнг улсын хэмжээний тайлан гаргах;

4.9. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн ажилтан болон олон нийтэд мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах.

Тав. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн чиг, үүрэг

5.1. Эрүүл мэндийн байгууллагаас гарч байгаа аюултай хог хаягдлын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зохион байгуулах;

5.2. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлаас үүсэж болох эрсдэлийн талаар олон нийтэд болон эрүүл мэндийн ажилтанд мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулах;

5.3. Эрүүл мэндийн байгууллагуудаас гарах цацраг идэвхт, химийн бодисын хог хаягдлын менежментийн чиглэлээр улсын хэмжээнд мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах;

5.4. Химийн бодис, цацраг идэвхт бодисоос хордох эрсдэлээс сэргийлэх, эрсдэл үүссэн үед хариу арга хэмжээ авч удирдлага, зохион байгуулалтаар хангах;

5.5. Цацраг идэвхт бодис, химийн бодисын цуглуулалт, хадгалалт, боловсруулалт, устгалтын байдалд хяналт үнэлгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

6.1. Хог хаягдлын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийг мөрдөн, байгууллагын үйл ажиллагаанд тохирсон хог хаягдлын зүй зохистой менежментийг хэрэгжүүлэх;

6.2. Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөтэй, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон байгууллагын төсөвт тусгах;

6.3. Үүсэж байгаа хог хаягдлын байдалд дүн шинжилгээ хийж аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах бодлого баримтлах;

6.4. Хог хаягдлын менежментэд шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, дахин ашиглах, боловсруулах, зөвшөөрөгдсөн аргаар устгахад зарцуулагдах санхүүгийн тооцоо судалгааг хийж төсөвт тусгаж байх;

6.5. Олон улсын болон Монгол улсын стандартад нийцсэн хог хаягдлын уут, сав, аюулгүй хайрцаг ашиглах. Хог хаягдалтай харьцаж ажиллаж байгаа ажиллагсдыг чанарыг шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгслээр хангах;

6.6. Хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, ажилтныг томилж ажиллуулах;

6.7. Хог хаягдлын менежментийн хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас дэмжлэг туслалцаа авч ажиллах;

6.8. Аюултай хог хаягдлын мэдээг хавсралт хүснэгтийн дагуу өдөр бүртгэж, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад сар бүрийн 5-ны өдрийн дотор мэдээлэх;

6.9. Аюултай хог хаягдалтай холбоотой осол гэмтэл, эрсдэлт нөхцөл байдал үүссэн үед шуурхай мэдээлэх, өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам, зааврын дагуу авч хэрэгжүүлнэ;

6.10. Аюултай хог хаягдлын менежментийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг сургах. Хог хаягдлын ажилтныг мэргэшүүлэх, аюултай хог хаягдлыг тээвэрлэх байгууллагын ажилтан, жолооч, ачигч нарт эрсдэлээс сэргийлэх сургалт, заавар, зөвлөмжөөр хангах;

6.11. Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч нарт ажлын талбарт гарахаас өмнө хог хаягдлын ангилан ялгалт, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр сургалт, зааварчилгаа өгөх;

6.12. Хог хаягдлын тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, зааврын хүрээнд эмнэлгийн аюултай хог хаягдлаас бусад энгийн хог хаягдлын менежментийг сайжруулж, дотоод хяналтыг бэхжүүлэх.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны ...
сарын 09-ны өдрийн 443 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зөөвөрлөх, түр хадгалах аргачлал, заавар

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор хог хаягдал түр хадгалах байр, түр хадгалах цэгрүү зөөвөрлөх, хадгалахад энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг нийтийн эзэмшлийн зам талбайгаар тээврийн хэрэгсэл ашиглан тээвэрлэхэд энэхүү заавар хамаарахгүй.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зөөвөрлөх

2.1. Тасаг, нэгж, хог хаягдал үүссэн цэг бүрээс хог хаягдлыг түр хадгалах байр хүртэл зөөх хамгийн оновчтой чиглэлийг тогтоож, цагийн хуваарь гаргасан байна. Зөөх маршрут нь аль болох олон хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу, үйлчилгээний ачаалал бага байх цагт тохируулна.

2.2. Хог хаягдлыг эрчимт эмчилгээ, гемодиализ, мэс засал, төрөх тасаг зэрэг хог хаягдал их хэмжээгээр үүсдэг тасаг нэгжүүдэд хог хаягдал хуримтлагдахаас сэргийлж зөөвөрлөх хуваарийг төлөвлөнө.

2.3. Тасаг нэгжүүдээс нэг зэрэг хог хаягдлыг цуглуулах маршруттай бол мэс засал, нярай, эрхтэн шилжүүлэх тасаг зэрэг халдварын эрсдэл өндөр тасгаас эхэлж цуглуулан халдваргүй бүст нэвтрэхгүйгээр зөөвөрлөнө.

2.4. Ууттай хог хаягдлыг ил задгай орхиж болохгүй, сав, тэргэнцэргүйгээр шууд зөөвөрлөх, аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөхийг хориглоно.

2.5. Халдвартай, зүү хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг түр хадгалах байр луу зөөвөрлөх хүртэл тасаг нэгж дотор түр хадгалах шаардлагатай бол "Био аюултай" таних тэмдэг бүхий таглаатай саванд хийж, цоожтой өрөө, эсвэл хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу газар, тусгай цэгт хадгална.

Гурав. Хог хаягдал цуглуулах уут, саванд тавигдах шаардлага

3.1. Халдвартай, эмгэг хог хаягдлын уут шар өнгөтэй, хими, эмийн болон эсэд хортой нөлөөтэй хог хаягдлын уут хүрэн өнгөтэй байна.

3.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагад нийцсэн хог хаягдал цуглуулах уутыг хэрэглэнэ.

3.3. Уутны гадна талд хог хаягдлын шинж чанараас хамаарч тусгайлсан "Био аюултай" таних тэмдгүүдийг харагдахуйц өнгөөр, томоор хэвлэсэн байна. Тэмдгийн дор тасаг, нэгжийн нэр, уут ашиглаж эхэлсэн цаг, огноог тэмдэглэж хаяглах хэсгийг хэвлэсэн байна.

3.4. Аюулгүй хайрцаг нь шингэн нэвчихгүй, хурц үзүүр иртэй зүйл нэвтэрч гарах эрсдэлгүй зузаан цаасан хайрцаг эсвэл хуванцар материалаар хийгдсэн байна.

3.5. Хогийн уут тогтоогч эсвэл хогийн савыг ашиглана. Хогийн сав болон уут тогтоогч нь өндөр нягтралтай хуванцар болон металл материалаар хийгдсэн, бат бөх, хөлөөр дарж онгойдог таглаатай байх бөгөөд овор ихтэй бол дугуйтай байж болно.

3.6. Хогийн уут, сав нь 10 – 250 литрийн багтаамжтай байх бөгөөд гарч байгаа хаягдлын хэмжээндээ тохирсон байна. Хогийн сав, уут тогтоогчийн гадна талын 3/4–т “Анхаар! Энэ түвшнээс дээш дүүргэж болохгүй” гэсэн тэмдэглэгээ, “Био аюултай” таних тэмдэгтэй байна.

3.7. Хог хаягдал үүсэж байгаа газарт ангилан ялгаж цуглуулах уут, савыг байршуулж, хог хаягдлыг зөв ангилах, овор хэмжээг багасгах талаар заавар, санамжийг тавьсан байна.

Дөрөв. Аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор зөөх сав, тэргэнцэрт тавигдах шаардлага

4.1. Халдвартай болон хурц иртэй, үзүүртэй хог хаягдлыг хуванцар болон хатуу материалаар хийгдсэн сав тагтай, бариултай сав эсвэл тэргэнцэр ашиглаж зөөвөрлөнө.

4.2. Тэргэнцэр, савны гадна талд нь “Био аюултай” таних тэмдэгтэй байна.

4.3. Ачиж, буулгахад хялбар, хурц, ирмэг үзүүргүй, гадаргуу нь мөлгөр, таглаатай, угааж, цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна.

4.4. Тэргэнцэр нь ажилтны харах талбайг хязгаарлахуйц хэт өндөр биш, түрэх болон чирч явахад тохирсон дугуйтай, дугуй нь түгжигддэг байна. Тэргэнцэр явах зам талбайг засаж, тохижуулан явахад хялбар болгож бэлтгэсэн байна.

4.5. Хог хаягдал тээвэрлэх тэргэнцэр, савыг өдөр бүр ажил дууссаны дараа угааж, халдваргүйжүүлнэ. Нөөцийн сав, тэргэнцэртэй байна.

Тав. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байр, цэгт тавигдах шаардлага

5.1. Эрүүл мэндийн байгууллагад үүсэж буй аюултай хог хаягдлын төрөл, хэмжээнээс хамааран түр хадгалах байр, эсвэл цэгтэй байна. Нэг өдөрт үүсэж буй аюултай хог хаягдлын нийт хэмжээ 20 килограмм орчим буюу түүнээс бага байвал түр хадгалах цэг, 20 килограммаас их байвал түр хадгалах байртай байна.

5.2. Түр хадгалах байранд тавигдах шаардлага

5.2.1. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, төрөлжүүлэн хадгалах, ажилтны амрах хэсэгтэй байна. Ажилтны амрах хэсэгт хувцас солих гар угаах, ариун цэврийн өрөөг зохион байгуулсан байна.

5.2.2. Хүлээн авах хэсэгт хог хаягдлыг жинлэн бүртгэнэ.

5.2.3. Хадгалах хэсэгт халдвартай, хурц үзүүр, иртэй хог хаягдал, химийн, эмийн эсэд хортой, цацраг идэвхт хаягдлыг зориулалтын саванд төрөлжүүлэн хадгална;

5.2.4. Гадны хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зайтай газарт байрлаж, шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байна.

5.2.5. Гадна талдаа хаяг, био аюулгүйн таних тэмдэг байрлуулсан.

5.2.6. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайтай;

5.2.7. Хана нь 2.0 метрээс доошгүй өндөртэй, хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой, шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай, бохир ус цуглуулах сувагт холбогдсон;

5.2.8. Цахилгаан, цэвэр бохир усны хэсгийн болон төвлөрсөн шугамд холбогдсон;

5.2.9. Гар угаах, бохир сав, тэргэнцэр угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн;

5.2.10. Нарны гэрэл шууд тусахгүй, сэрүүн (18° С хүртэл, 60%-иас ихгүй чийглэгтэй), нэгдсэн болон хэсгийн нэмэлт агааржуулалт сайтай байх;

5.2.11. Зориулалтын 0,1-120 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй;

5.2.12. Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйц том, тод бичиж хананд байрлуулсан байна.

5.3. Түр хадгалах байранд хог хаягдлыг бутлах, халдваргүйжүүлэлт хийхээр зохион байгуулсан үед тавигдах шаардлага

5.3.1. Түр хадгалах байр нь нэг чиглэлийн урсгалтай, ханаар тусгаарласан цэвэр, бохир хэсэгтэй байна.

5.3.2. Бохир хэсэгт аюултай хог хаягдлыг хүлээн авах, төрөлжүүлэн хадгалах, автоклавт халдваргүйжүүлэн бутлах, хогийн сав, тэргэнцэр халдваргүйжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

5.3.3. Боловсруулсан хог хаягдлыг эцсийн устгалын цэг рүү тээвэрлэх хүртэл түр хадгална.

5.3.4. Цэвэр хэсэгт бүртгэл, нөөцийн өрөө, ажилтны хувцас солих, гар угаах угаах, усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

5.4. Түр хадгалах цэгт тавигдах шаардлага

5.4.1. Гаднын хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зайтай газарт байрлаж, шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байх;

5.4.2. Шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай, хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой байх;

5.4.3. Нарны гэрэл шууд тусахгүй, сэрүүн (18° С хүртэл, 60%-иас ихгүй чийглэгтэй), агааржуулалт сайтай байх;

5.4.4. Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах боломжтой байх;

5.4.5. Хог хаягдлыг жинлэх зориулалттай, 0,1-50 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй байх

5.5. Түр хадгалах байр, цэгийн гадна дараах хаяг, таних тэмдэг тэмдэглэгээг байршуулна.

5.5.1. Гадна талдаа “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг түр хадгалах байр” гэсэн хаяг, дараах таних тэмдэгтэй байна. Таних тэмдэг нь нүдэнд харагдахуйц, тод бичигдсэн байна.



5.5.2. Дотор талдаа дараах таних тэмдэгтэй байна.



**Аюултай хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн болон хэсгийн
байгууламжид тавигдах шаардлага**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү заавар нь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах хэсгийн болон төвлөрсөн байгууламжид мөрдөгдөнө.

1.2. Төвлөрсөн байгууламж нь зориулалтын барилга, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинтэй, батлагдсан журам, зааврын дагуу үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна.

1.3. Хэсгийн байгууламж нь эрүүл мэндийн байгууллагаас үүсч байгаа хог хаягдлын хэмжээнд тохирсон тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажиллах хүний нөөцтэй байна.

1.4. Төвлөрсөн байгууламжид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн байна.

1.5. Энэхүү зааварт тусгагдаагүй бусад асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмаар зохицуулна.

Хоёр. Төвлөрсөн байгууламжийн барилгад тавигдах ерөнхий шаардлага

2.1. Батлагдсан зураг төсөл, стандарт, барилгын норм, дүрмийн дагуу баригдсан, улсын комисст хүлээлгэн өгсөн, зориулалтын барилга бүхий төвлөрсөн байгууламжид эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулна.

2.2. Төвлөрсөн байгууламж нь нийтийн суурьшлын бүс болон олон нийтийн газраас зайтай, ундны усны эх үүсвэрээс хол, үерт автахааргүй газарт хот суурингийн зонхилох салхины доор байрлана.

2.3. Байгууламж нь цэвэр, бохир усны хэсгийн болон төвлөрсөн системд холбогдсон, цахилгааны төвийн эх үүсвэртэй, үерийн далан, сувагтай, бохир ус цэвэрлэх байгууламжтай байна.

2.4. Хог хаягдал боловсруулах төвлөрсөн байгууламжийн барилга нь ажиллагсдын амрах, усанд орох, хооллох өрөө болон захиргаанаас тусдаа байрлана.

2.5. Тээврийн хэрэгсэл саадгүй хүрэх, барилга, зам байгуулах боломжтой газар байвал зохино.

2.6. Мал амьтан, гадны хүн орохооргүй, хашаа хамгаалалттай, байнгын харуултай, гадна талдаа хаяг, био аюулгүйн таних тэмдэг байрлуулсан, 1,8 га-с багагүй эдэлбэр газартай, эдэлбэр газрын 60%-аас доошгүй газарт ногоон байгууламжтай байна.

2.7. Гадны хүн, амьтан орохоос сэргийлж, цоожтой хаалга бүхий хашаатай, хашааны өндөр нь 1,8 метрээс багагүй байна. Бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.

2.8. Шингэн хаягдал гадагш урсахгүй, хор хөнөөлийг бууруулах арга хэмжээ авах боломжтой байна.

2.9. Барилга нь 8-10 баллын газар хөдлөлтөнд тэсвэртэй байх бөгөөд утаа мэдрэгч тоног төхөөрөмж, аянга зайлуулах газардуулгатай байна.

2.10. Аюулгүй байдлын үүднээс байгууламжийн хашаанд онцгой байдал, ослын үед байрны өөр талаас нь нэвтрэх зорилгоор нэмэлт хаалга гаргаж болно.

Гурав. Барилгын зохион байгуулалт, тавигдах шаардлага

3.1. Төвлөрсөн байгууламж нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

3.1.1. Аюултай хог хаягдал хүлээн авах хэсэг. Энэ хэсэгт цуглуулсан хог хаягдлыг тээврийн хэрэгслээс буулгаж, жигнэж, бүртгэнэ.

3.1.2. Түр хадгалах хэсэг. Энэ хэсэгт аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн, зориулалтын саванд хадгална.

3.1.3. Халдваргүйжүүлэх хэсэг. Халдвартай хог хаягдлыг халдваргүйжүүлж бутална.

3.1.4. Халдваргүйжүүлсэн хог хаягдлыг түр хадгалах хэсэг. Халдваргүйжүүлсэн хог хаягдлыг эцсийн устгалын цэг рүү тээвэрлэх хүртэл түр хадгална.

3.1.5. Тээврийн хэрэгсэл, хогийн сав угаах, халдваргүйжүүлэх хэсэг. Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлж, угааж цэвэрлэнэ.

3.1.6. Цэвэр хогийн сав хадгалах хэсэг. Халдваргүйжүүлж, цэвэрлэсэн хог хаягдлын сав, тэргэнцрийг хадгална.

3.1.7. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн хэсэг. Техник хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах хэрэгсэл тухайлбал, уур үүсгэгч, даралттай агаарын генератор, ус зөөлрүүлэгч гэх мэт болон засвар үйлчилгээний зүйлсийг хадгална.

3.1.8. Захиргааны хэсэг. Энэ хэсэгт оффис өрөө, ажилчдын амрах өрөө, хоолны газрыг зохион байгуулна.

3.1.9. Хувцас солих, угаалга, усанд орох өрөөтэй байна.

Дөрөв. Хүний нөөцөд тавигдах шаардлага

4.1. Төвлөрсөн байгууламж нь өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай мэргэжилтэн, ажиллах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

4.1.1. Эрүүл ахуйч, тархвар судлагч

4.1.2. Тоног төхөөрөмжийн инженер

4.1.3. Автоклавын оператор

4.1.4. Шатаах зуухны оператор

4.1.5. Бутлагч машины оператор

4.1.6. Угаалгын ажилтан

4.1.7. Жолооч /Аюултай хог хаягдлын тээврийн хэрэгсэл бүрд/

4.1.8. Ачигч /Аюултай хог хаягдлын тээврийн хэрэгсэл бүрд, төвлөрсөн байгууламжид ээлж бүрд/

4.1.9. Үйлчлэгч

4.2. Бүх ажилтнууд нь сертификат бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, халдвараас сэргийлэх холбогдох сургалтуудад хамрагдсан байна.

4.3. Операторууд нь даралтат савтай харьцах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна.

4.4. Бүх ажилтнууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жил бүр хамрагдахаас гадна В вируст гепатит, татрангийн эсрэг дархлаажуулалтад хамрагдана. Гепатитын В вирусийн вакцинд хамрагдсан бол дархлал тогтцын шинжилгээ хийлгэсэн байна.

4.5. Хувийн хамгаалах хэрэгслээр тухайлбал, тоос тоосонцор утаа шүүх зориулалт бүхий амны хаалт нүүрний хамгаалалт, дулаанд тэсвэртэй бээлий, ажлын хувцас, гутал, гэх мэт хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд шаардлагатай хэрэгслийг зөв хэрэглэнэ.

Тав. Хог хаягдлыг шатаах байгууламжид тавигдах шаардлага

5.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг шатаах аргаар боловсруулах байгууламжид хамаарна.

5.2. Шатаах байгууламж нь шатаах зуух бүхий өрөө, шаталтын дараах хэсэг, агаарын бохирдлын хяналтын хэрэгсэл, хаягдал ус боловсруулах хэсгүүдтэй байна.

5.3. Шатаах байгууламжийн хана, шал, таазыг галд тэсвэртэй материалаар хийнэ.

5.4. Шатаах зуух бүхий өрөө нь хог хаягдлыг түр хадгалах өрөөтэй холбогдсон, хана, таазнаас 1,5 метрээс доошгүй зайтай байна.

5.5. Хог хаягдлыг зуух руу хийх автомат системтэй байна.

5.6. Шатаах хэсэгт дулааныг тохиромжтой түвшинд барьж байхын тулд автоматаар ажилладаг асаагуур суурилуулна.

5.7. Шатаах зуухны дулаан, даралтын уналт, угаарын хий, нүүрстөрөгчийн давхар исэл, хүчилтөрөгчийн түвшин зэрэг чухал шаардлагатай шаталтын гол үзүүлэлтүүдийг тасралтгүй хянаж байх системтэй байна.

5.8. Агаарын бохирдлын хяналтын систем суурилагагүй шатаах зуух ашиглахыг хориглоно. Агаарын бохирдлын хяналтын систем нь яндан дахь дэгдэмхий бодис, хорт хийг цэвэрлэх чийгтэй системтэй байна.

5.9. Шатаах байгууламжид гаднын хүн орохыг хориглоно.

5.10. Шатаах зуухны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэл хөтөлнө. Шатаах зуухны хэвийн үйл ажиллагааны алдагдал гарсан тохиолдолд засвар үйлчилгээний хэсэгт цаг алдалгүй мэдэгдэнэ.

5.11. Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйц том, тод бичиж хананд байрлуулсан байна.

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах хэсгийн байгууламжид тавигдах шаардлага

6.1. Хэсгийн байгууламжийн барилгад тавигдах ерөнхий шаардлага

6.1.1. Байгууламж нь цэвэр, бохир усны хэсгийн болон төвлөрсөн системд холбогдсон, тоног төхөөрөмж ашиглах техникийн нөхцөлийг хангасан цахилгааны эх үүсвэртэй байна.

6.1.2. Байгууламж нь нэг чигийн урсгалтай, цэвэр бохир хэсгээр тусгаарлагдсан байна.

6.1.3. Өрөө нь төхөөрөмжийн овор хэмжээ, техникийн шаардлагад тохирсон, үйл ажиллагаа явуулахад чөлөөтэй зай талбайтай, ажилтны ажиллах нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангасан байна.

6.1.4. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, төрөлжүүлэн хадгалах, боловсруулах, хог хаягдлын савны угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт зэрэг үйл ажиллагаа нь бохир хэсэгт, бусад үйл ажиллагааг цэвэр хэсэгт төлөвлөнө.

6.1.5. Хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой материалтай, шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай, бохир ус цуглуулах сувагт холбогдсон байна.

6.1.6. Байгалийн болон HEPA шүүлтүүр бүхий нэмэлт агааржуулалтын системтэй байна.

6.1.7. Химийн, эмийн, эсэд хортой, цацраг идэвхт зэрэг хэсгийн байгууламжид боловсруулах, устгах боломжгүй хог хаягдлыг тусад нь зориулалтын саванд төрөлжүүлэн хадгалж, холбогдох хууль, дүрэм, зааврын дагуу мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгнө.

6.1.8. Хүн, амьтан орохоос сэргийлсэн цоож бүхий хаалгатай, гадны хүн орохыг хориглосон анхааруулах тэмдэгтэй байна. Тэмдгийг тод, ил, харагдахуйц байрлуулна.

---o0o---

9	Хэрэглээнээс гарсан зай цуглуулах сав	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
10	Химийн бодис хадгалах тавиур, шүүгээ	+	+		+	+	+						
11	Хөргөгч	+	+		+	+	+						
12	Лабораториос гарах өсгөвөр, тэжээлт орчин халдваргүйжүүлэх автоклав	+	+		+	+	+						
13	Хог хаягдал халдваргүйжүүлэх автоклав				+					+	+		
14	Бутлагч				+								
15	Жин	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
16	Автомат	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
17	Даралттай ус шүршигч, уртасгагч усны хоолой	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, тавигдах шаардлага

№	Тоног төхөөрөмж	Тавигдах шаардлага	Зориулалт	Жишиг зураг
Нэг. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн зарим тоног төхөөрөмж				
1.1.	Автомат	Дараах дагалдах хэрэгсэл: - Гангаар хийгдсэн шүршигч хэсэг, - Даралттай шүршигч хоолой, - Дарахад хялбар гох, мөрөнд тогтоогч	Сав, хогийн сав, бусад зүйлсийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх зориулалт бүхий шүршигч	
1.2.	Усны хоолой	Материал: Хуванцар	Урд талд нь хошуу хийж хог хаягдлын тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх, хадгалах сав, тэргэнцэр цэвэрлэх зориулалт бүхий усны хоолой	
1.3.	Даралттай ус шүршигч /зөөврийн/	Дараах дагалдах хэрэгсэл: - Гангаар хийгдсэн шүршигч хэсэг, - Даралттай шүршигч хоолой, - Дарахад хялбар гох, - 220V, 50Hz ажиллах боломжтой	Хог хаягдлын тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх, хадгалах сав, тэргэнцэр, хана шалны бохир хэсгийг даралттай усаар шүршиж цэвэрлэх	
1.4.	Ус шахагч насос	Цахилгаан: 220 V, 50 Hz	Холбогдох тоног төхөөрөмжид шаардлагатай усны даралтыг 4 бар хүртэл нэмэгдүүлж, үйл ажиллагааны найдвартай байдлыг хангах	

1.5.	Автоклавын ус шүүгч	Шүүгч: сольдог	Автоклавт хэрэглэгдэх усыг шүүх	
1.6.	Цахилгааны хүчдэл тогтворжуулагч	Автомат тохируулгатай	Цахилгаан хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүчдэлийн хэлбэлзлээс шалтгаалсан үйл ажиллагааны доголдлоос сэргийлэх	
Хоёр. Хог хаягдал цуглуулах, хадгалах, зөөвөрлөх, тээвэрлэх хэрэгсэл				
2.1.	Хог хаягдлын уут	Зузаан: 7 микроноос доошгүй -Зөвхөн нэг удаа ашиглана -Автоклавдах боломжтой -Шар болон хүрэн уутан дээр "Био аюултай" таних тэмдэгтэй -Шар, хүрэн	Хог хаягдал цуглуулах	
2.2.	Хог хаягдлын жижиг хогийн сав	Материал: Хуванцар (PE-полиэтилен) - Хөнгөн, зөөхөд хялбар - Халдваргүйжүүлэх бодист тэсвэртэй -Тагтай - Хөлөөрөө дарж онгойлгодог - Цэвэрлэхэд хялбар, гөлгөр гадаргуутай -"Био аюултай" таних тэмдэгтэй	Хог хаягдал цуглуулах	
2.3.	Аюулгүйн хайрцаг	Материал: Хуванцар, цаасан -"Био аюултай" таних тэмдэгтэй - Хуванцар аюулгүйн хайрцаг нь тагтай, зүү мултлагчтай байна. - Шингэн нэвтэрдэггүй - Зүү нэвтэрдэггүй - Автоклавдах боломжтой	Зүү, хурц иртэй, үзүүртэй хог хаягдал цуглуулах	 

2.4.	Энгийн хог хаягдал цуглуулах сав	Материал: Хуванцар (PE-полиэтилен) -Хөнгөн, зөөхөд хялбар -Угаалга, халдваргүйжүүлэх бодист тэсвэртэй -Тагтай -Хөлөөрөө дарж онгойлгодог -Цэвэрлэхэд хялбар, мөлгөр гадаргуутай -Хар/саарал өнгөтэй	Аюулгүй хог хаягдлыг (энгийн) цуглуулах зориулалттай	
2.5.	Энгийн хог хаягдал зөөвөрлөх зориулалт бүхий дугуйтай хогийн сав	Материал: Өндөр нягтралтай хуванцар -Эрсдэлгүй, хатуу хог хаягдал хийх зориулалттай -Хэт ягаан туяа, өндөр хэмд тэсвэртэй -Хог наалдахаас сэргийлсэн гөлгөр гадаргуутай -Химийн болон биологийн нөлөөнд тэсвэртэй -Хар/саарал өнгөтэй	Энгийн хог хаягдал бүхий ууттай хогийг цуглуулж зөөвөрлөх	
2.6.	Аюултай хог хаягдал цуглуулах сав	Материал: Нягтрал сайтай хуванцар -Хөнгөн, зөөхөд хялбар -Хүчил, шүлтэд тэсвэртэй -Цэвэрлэхэд хялбар -2 талдаа бариултай -Таг нь түгжигддэг -Шар өнгөтэй, -Дугуйтай -“Био аюултай” таних тэмдэгтэй	Аюултай хог хаягдал бүхий ууттай хог хаягдлыг тасаг, нэгжид түр хадгалах, зөөвөрлөх	
2.7.	Аюултай хог хаягдал бүхий савыг зөөвөрлөх тэргэнцэр	Зөөвөрлөхөд хялбар дугуйтай байх Материал: Төмөр, металл	Аюултай хог хаягдал бүхий савыг зөөвөрлөх	
2.8.	Аюултай хог хаягдал зөөвөрлөх сав	Материал: Өндөр нягтралтай хуванцар (HDPE) -Сав нь 1м-ээс өндөргүй байх	Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх	
2.9.	Өдрийн гэрэл хадгалах сав	Материал: Төмөр/ өндөр нягтралтай хуванцар (HDPE) -Түгжигддэг, тагтай байх - Гадна талдаа 3/4хэсэгт таних тэмдэгтэй - 2 талдаа бариултай - Бат бөх, давхарлаж тавих бололцоотой байх	Хагарсан, шатсан өдрийн гэрэл, чийдэн цуглуулах, зөөвөрлөх	

2.10.	Аюултай хатуу хог хаягдал тээвэрлэх сав	Материал: Полиэтилен - Авагддаг тагтай байх - Гадна талдаа таних тэмдэг тавих хэсэгтэй - Бат бөх, давхарлаж тавих бололцоотой байх	Эрүүл мэндийн байгууллагаас гарах аккумулятор, зай болон бусад хүнд металл агуулсан багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг цуглуулж хадгалах	
2.11.	Жин –электрон	- Цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд хялбар - Хэмжих, уншихад хялбар - Ус нэвтэрдэггүй материалаар хийгдсэн байх	Эрүүл мэндийн байгууллагын төрөл бүрийн хог хаягдлыг жигнэх	
2.12.	Химийн бодисын хог хаягдал хадгалах тавиур	Материал: цайрдсан ган, зэвэрдэггүй Тогтвортой, унахаас сэргийлж нэмэлт бэхэлгээ хийх	Хатуу болон шингэн химийн хог хаягдлыг хадгалах	 
2.13.	Химийн бодисыг аюулгүй хадгалах сав	Материал: Хэт ягаан туяа болон химийн бодист тэсвэртэй хуванцар(PE) - Савнуудыг тээвэрлэхэд хялбар болгох үүднээс тавиур дээр тавих боломжтой байх - Савны гадрыг цэвэрлэхэд хялбар байх - Эргэгддэг таглаатай байх	Идэмхий шүлт, хүчил, фотохимийн бодис зэрэг шатамхай бус шингэн, химийн бодис хадгалах	 
2.14.	Шингэн цуглуулах тавиур	Материал: Хэт ягаан туяанд тэсвэртэй Полиэтилен (PE) - Шингэн химийн бодистой савыг тавиур дээр тавих - Цэвэрлэхэд хялбар	Шингэн, химийн бодис асгарахад цуглуулах зориулалт бүхий тавиур	
2.15.	Автомашин	Гидролик өргөгч Бүхээгтэй -Ачааны бүхээг хөргүүртэй -Бүхээг нь цоожлогддог -Дугуйтай тэргэнцрийг өргөгчөөр ачих боломжтой -Шал нь тэгш гадаргуутай	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх	
Гурав. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл				
3.1.	Хамгаалах нүдний шил	Материал: Зурагддаггүй хуванцар -Цантдаггүй -Уяаг толгойд тааруулах боломжтой	Нүд хамгаалах хэрэгсэл	

3.2.	Нүүрний хаалт	Материал: Зурагддаггүй хуванцар -Цантдаггүй -Уяаг толгойд тааруулах боломжтой	Нүд хамгаалах хэрэгсэл	
3.3.	Ажлын бээлий	Материал: Хуванцар бүрэлттэй зузаан бөс даавуу	Химийн бодистой харьцах, бохирын системтэй ажиллах явцад хэрэглэх	
3.4.	Зүү нэвтэрдэггүй бээлий	Материал: Нэхмэл кевлар доторлогоотой, нитрил бутадиен гадаргатай, тефлон ган ялтсаар хийгдсэн байна Үрэлтэд тэсвэртэй байдал: (1-4): Түвшин 3 Зүсэлтэд тэсвэртэй байдал: (1-5): Түвшин 5 Урагддаггүй байдал: (1-4): Түвшин 4 Хатгалт, цоололтод тэсвэртэй байдал: (1-4): Түвшин 4	Хурц үзүүртэй, иртэй зүйлд хатгуулсны улмаас гэмтэл авах, хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллах явцад зүсэх, хатгуулахаас хамгаалах зориулалт бүхий хувийн хамгаалах хэрэгсэл	
3.5.	Ахуйн бээлий	Материал: Нитрил гадаргуутай бат бөх сүлжмэл	Аюулгүй материалтай (ахуйн хог хаягдал, дахин боловсруулах хог хаягдал г.м.) харьцаж ажиллах зориулалт бүхий хувийн хамгаалах хэрэгсэл	
3.6.	Халуунд тэсвэртэй ажлын бээлий	Материал: Кевлараар хийгдсэн Аюулгүйн ангилал: CE 3	Хог хаягдалтай уутыг өндөр даралттай уураар халдваргүйжүүлэх автоклав, шатаах зууханд хийх, гаргаж авахад ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	
3.7.	Хөдөлмөр хамгааллын хувцас / комбинзон, өмд цамц, хүрэм	Материал: Хөвөн даавуу -Сайн чанарын, бат бөх, угааж цэвэрлэхэд хялбар, урдуураа цахилгаантай -Энгэртээ 2 цахилгаантай халаастай, ар ташаандаа 2 том, цахилгаан бүхий халаастай	Хог хаягдалтай уутыг өндөр даралттай уураар халдваргүйтгэх автоклав, шатаах зууханд хийх, гаргаж авахад ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	
3.8.	Хормогч, ханцуйвч	Материал: Хулдаас -Химийн бодист тэсвэртэй -Шингэн нэвтрүүлдэггүй	Шингэн бодистой харьцах, хог хаягдлын сав, тэргэнцэрийг халдваргүйжүүлэх, угаах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл	

3.9.	Хамгаалалт бүхий ажлын гутал	Материал: Шир Давхар нягтралтай полиуретан Аюулгүйн ангилал: EN345 (200 Жоуль). -Ширэн гадартай, доторлогоотой -200°C халуунд тэсвэртэй, ган улавчтай -Бензин, тос, хүчил, шүлтэнд тэсвэртэй, цахилгаанждаггүй материалаар хийсэн ултай	Хөл хамгаалах хувийн хэрэгсэл	
3.10.	Химийн бодист тэсвэртэй хамгаалалтын ажлын гутал	Материал: Полистер Аюулгүйн ангилал: EN 345 (200 Жоуль) -PVC гадна талтай -Бензин, тос, хүчил, шүлтэд тэсвэртэй,	Хөл хамгаалах хувийн хэрэгсэл	

Эрүүл мэндийн байгууллагын хэсгийн байгууламжид ашиглах хог хаягдал боловсруулах төхөөрөмжийн зарим үзүүлэлт

Төхөөрөмжийн нэр	Хог хаягдал боловсруулалт	Хүчин чадал	Ажиллах температур/мөчлөг	Эзлэхүүн багасгах
Sterilwave SW 100 (Австри)	Бичил долгионоор халдваргүйжүүлэх Бутлах	20 кг/цаг	100-110°C (30 минут)	85%
Promed P150 (Турк)	Бичил долгионоор халдваргүйжүүлэх Халуун уураар халдваргүйжүүлэх Бутлах	33-70 кг/цаг	134-150°C (25-30 минут)	-
Newster NW 15 (Итали)	Үрэлтийн дулаан Бутлах	30-40 кг/цаг	150°C (35-40 минут)	20-25%
Steriplus 40 (Франц)	Халуун уураар халдваргүйжүүлэх Бутлах	5-10 кг/цаг	135 °C (30-35 минут)	80%
Sambion IMS 200 (Энэтхэг)	Бичил долгионоор халдваргүйжүүлэх Бутлах	20-25 кг/цаг	100-110°C (30 минут)	85%
CHW-LXB 50L-D (Хятад)	Халуун уураар халдваргүйжүүлэх	35-50 л/цаг	100-134°C	-

п мэндийн сайдын 2025 он
н 09-ны өдрийн *Агуу* ду
алын тавдугаар хавсралт

1. Эрүүл мэндийн байгууллагад үүсэж байгаа аюултай хог хаягдлыг өдөр бүр бүртгэнэ.

3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа байгууллагуудын мэдээг нэгтгэж, ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны албанд сар бүрийн 10-ны дотор цахимаар хургуулнэ.

4. ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт судалгааны алба нь мэдээнд дүн шинжилгээ хийж ЭМЯ-нд жил бүр тайлагнана.

Тасаг, нэгжийн нэр:

[illegible]

Жич: Тасаг, нэгжүүд аюултай хог хаягдлыг өдөр бүр бүртгэж, тухайн байгууллагын тархвар судлаач нэгтгэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт сар бүр хүргүүлнэ.

Байгууллагын нэр:.....
Тээврийн хэрэгслийн дугаар:.....
Жолоочийн нэр, утас:

				Хог ачиж тээвэрлэсэн огноо
				Халдвартай хог хаягдал /кг/
				Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал /кг/
				Эмгэг хог хаягдал /кг/
				Эмийн болон эсэд хортой хог хаягдал /кг/
				Химийн хог хаягдал /кг, л/
				Цацраг идэвхт хаягдал
				Тээврийн хэрэгслийн дугаар
				Хүлээлгэн өгсөн хүний нэр
				Хүлээн авсан хүний нэр

Хүснэгт 3. Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах байгууламжид хүлээлгэн өгөх бүртгэлийн маягт

Тээврийн хэрэгслийн дугаар.....Жолоочийн нэр, утас.....

Эрүүл мэндийн байгууллагын нэр	Халдвартай хог хаягдал /кг/	Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал /кг/	Эмгэг хог хаягдал /кг/	Эмийн болон эсэд хортой хог хаягдал /кг/	Химийн хог хаягдал /кг, л/	Цацраг идэвхт хаягдал	Хүлээн авсан хүний нэр

Жич: Энэхүү хүснэгтийг аюултай хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагын тээврийн хэрэгслийн жолооч хог хаягдлыг боловсруулах байгууламжид хүлээлгэн өгөхдөө хөтөлнө.

Хүснэгт 4. Халдвартай хог хаягдлыг халдваргүйжүүлсэн бүртгэлийн маягт

Эрүүл мэндийн байгууллагын нэр:

Огноо: он.....сар.....өдөр

Цикл	Халдвартай хог хаягдлын хэмжээ	Халдваргүйжүүлж эхэлсэн цаг, минут	Халдваргүйжүүлж дууссан цаг, минут	Ашигласан горим	Ажилтны овог нэр	Холбоо барих утасны дугаар	Гарын үсэг
1							
2							
3							

Хүснэгт 5. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тайлангийн маягт

Эрүүл мэндийн байгууллагын нэр:	Байршил		ЭМБ-ын тусламж үйлчилгээний шатлал:
.....	УБ	Орон нутаг	
1. Аюултай хог хаягдал ангилан цуглуулалт			
Аюултай хог хаягдлын төрөл		Хог хаягдлын хэмжээ	
Халдвартай (кг)			
Зүү, хурц үзүүртэй, иртэй (кг)			
Эмгэг (кг)			
Эмийн болон эсэд хортой (кг)			
Химийн (кг, л)			
Цацраг идэвхт (кг)			
2. Боловсруулалт устгал			
Халдвартай	хэмжээ (кг)	Зүү, хурц үзүүртэй, иртэй	хэмжээ (кг)
Автоклавт халдваргүйжүүлсэн		Автоклавт халдваргүйжүүлсэн	
Автоклавт халдваргүйжүүлээд бүтэлсэн		Автоклавт халдваргүйжүүлээд бүтэлсэн	

Химийн аргаар халдваргүйжүүлсэн			
Агаарын бохирдлын хяналттай зууханд өндөр хэмд шатаасан		Агаарын бохирдлын хяналттай зууханд өндөр хэмд шатаасан	
Ландфилдсэн		Ландфилдсэн	
Төвлөрсөн байгууламжид устгалд өгсөн		Төвлөрсөн байгууламжид устгалд өгсөн	
Бусад төрлийн зууханд шатаасан		Бусад төрлийн зууханд шатаасан	
Хамгаалсан нүхэнд булсан		Хамгаалсан нүхэнд булсан	
Бусад		Бусад	
Эмийн болон эсэд хортой	хэмжээ (кг)	Эмгэг	хэмжээ (кг)
Ханган нийлүүлэгчид буцааж өгсөн		Эхсийн нүхэнд хийсэн	
Төвлөрсөн байгууламжид устгалд өгсөн		Төвлөрсөн байгууламжид устгалд өгсөн	
Агаарын бохирдлын хяналттай зууханд өндөр хэмд шатаасан		Агаарын бохирдлын хяналттай зууханд өндөр хэмд шатаасан	
Капсулдсан		Ландфилдсэн	
Бусад		Бусад	
Химийн	хэмжээ (л, кг)	Цацраг идэвхт	хэмжээ (л, кг)
Агаарын бохирдлын хяналттай зууханд өндөр хэмд шатаасан		Хяналтаас чөлөөлөх түвшинд хүртэл хадгалаад устгасан	
Төвлөрсөн байгууламжид устгалд өгсөн		Хадгалах байгууламжид хүлээлгэн өгсөн	
Ханган нийлүүлэгчид буцааж өгсөн		Ханган нийлүүлэгчид буцааж өгсөн	
Бусад		Бусад	
Мэдээлсэн он сар _____ он _____ сар _____ өдөр /компьютерын хуанлингаар сонгоно/		Мэдээлсэн ажилтны нэр..... Албан тушаал.....	

Жич: Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Хүснэгт 1-ийн бөглөсөн мэдээллийг нэгтгэн, ХӨСҮТ-ийн Халдварт өвчний тандалт, судалгааны албанд сар бүр хүргүүлнэ.

Хүснэгт 6. Эмийн хог хаягдлыг хүлээлцэх маягт

Хүлээн авсан байгууллага:

Хүлээлгэн өгсөн байгууллага:

Огноо _____

№	Эмийн хог хаягдлын нэр, Олон Улсын нэршил	Үйлдвэрлэгч	Серийн дугаар	Хэмжих нэгж /ш, мл, кг/	Тоо хэмжээ	Устгал хийх шалтгаан	Эмийн үйлчлэл

--	--	--	--	--	--	--	--

Хаягдлыг хүлээлгэн өгсөн хүний албан тушаал _____

Нэр _____ / _____ /

Гарын үсэг _____

Холбоо барих утасны дугаар _____

Хаягдал хүлээн авч тээвэрлэсэн машины дугаар _____

Ажилтны нэр _____

Гарын үсэг _____

Хүснэгт 7. Химийн хог хаягдлыг хүлээлцэх маягт

Хүлээн авсан байгууллага:

Хүлээлгэн өгсөн байгууллага:

Огноо _____

№	Химийн хог хаягдлын нэр	Үйлдвэрлэгч	Код	Төлөв байдал	Хэмжих нэгж /ш, мл, кг/	Тоо хэмжээ	Устгал хийх шалтгаан	Хор аюулын талаарх тэмдэглэл /түлэх, цочроох, амьсгал боох гм/

Хаягдлыг хүлээлгэн өгсөн хүний албан тушаал _____

Нэр _____ / _____ /

Гарын үсэг _____

Холбоо барих утасны дугаар _____

Хаягдал хүлээн авч тээвэрлэсэн машины дугаар _____

Ажилтны нэр _____

Гарын үсэг _____

Хүснэгт 8. Нэр хаяг тодорхойгүй, холимог бодисыг хүлээлцэх маягт

Хүлээн авсан байгууллага:

Хүлээлгэн өгсөн байгууллага:

Огноо _____

№	Холилдсон бодисын нэр	Хэрэглээний зориулалт	Төлөв байдал	Хэмжих нэгж /ш, мл, кг/	Тоо хэмжээ	Савлагдсан байдал

Хаягдлыг хүлээлгэн өгсөн хүний албан тушаал _____

Нэр _____ / _____ /

Гарын үсэг _____
 Холбоо барих утасны дугаар _____
 Хаягдал хүлээн авч тээвэрлэсэн машины дугаар _____
 Ажилтны нэр _____
 Гарын үсэг _____

Хүснэгт 9. Цацраг идэвхт хаягдлын бүртгэлийн маягтууд

9.1. Цацраг идэвхт эм үйлдвэрлэлийн хэсгийн хог хаягдлын бүртгэл

Халуун лабораториос гарах хог хаягдлын бүртгэл									Чанарын хяналтын лабораториос гарах хог хаягдлын бүртгэл																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																												
																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																																					</

9.2. Цацраг идэвхт хаягдал гаргадаг эмчилгээний тасгуудад хөтлөгдөх бүртгэл

Огноо	Кarl 100 иж бүрдэл, ширхэг (мкЗв/цаг)	RAD-Inject иж бүрдэл, ширхэг (мкЗв/цаг)	Тариа хийх иж бүрдэл, ширхэг (мкЗв/цаг)	Уян зүү, ширхэг (Бк/см ²)	Тариур, ширхэг	Спирттэй хөвөн, ширхэг (Бк/см ²)	Спирттэй хөвөн, ширхэг	Сахарын тест, ширхэг	Флаккон (хөнгөн цагаан, резинэн тагтай), ширхэг мкЗв/цаг	Бээлий, Бк/см ²	Цаас, Бк/см ²	Гарын үсэг

9.3 Үйлдвэрлэлийн хэсгийн цацраг идэвхт-хаягдлыг чөлөөлөх хуудас

Хог хаягдлын төрөл	Жин /кг/ /Эзлэхүүн /мл/	Өмнөх 7 хоногийн 5 дахь өдрийн идэвх мкЗв/цаг /огноо	1 дэх өдрийн идэвх /огноо	Цацрагаас чөлөөлөх түвшин	Цацрагаас чөлөөлсөн эсэх тийм/үгүй	Тайлбар	Гарын үсэг

Эмийн болон эсэд хортой хог хаягдал				0,15 мкЗв/цаг-аас бага			
Химийн хог хаягдал							
Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал							
Шингэн хог хаягдал							

9.4. Эмчилгээний тасаг, хэсгийн цацраг идэвхт хаягдлыг чөлөөлөх хуудас

Хог хаягдлын төрөл	Жин /кг/	Өмнөх 7 хоногийн 5 дахь өдрийн идэвх мкЗв/цаг /огноо	1 дэх өдрийн идэвх /огноо	Цацрагаас чөлөөлөх түвшин	Цацрагаас чөлөөлсөн эсэх тийм/үгүй	Тайлбар	Гарын үсэг
Эмийн болон эсэд хортой хог хаягдал				0,15 мкЗв/цаг-аас бага			
Химийн хог хаягдал							
Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал							
Халдвартай хог хаягдал							
Шингэн хог хаягдал							

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 сарын 09-ны өдрийн 443 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

Зоонозын шалтгаант халдварт өвчний үед мал, амьтны үхдэл, сэг зэм устгах заавар

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Зоонозын халдварын тандалт, оношилгоо, судалгаа, шинжилгээний үед үүссэн мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг устгахад энэхүү тушаалыг мөрдөнө.

1.2. Эмгэг хог хаягдлыг шатаах, булшлах, тээвэрлэх, устгахад хэрэглэсэн эд зүйлс, хамгаалах хувцас хэрэглэл, лабораторийн оношилгоо, шинжилгээнд ашигласан материал, өсгөвөр, тэжээлт орчныг аюултай хог хаягдлын ангиллын дагуу ялган цуглуулж, нийтлэг зааврыг баримтална.

1.3. Зоонозын халдварын үед мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг дараах аргуудаар устгана. Үүнд:

1.3.1. Аюултай хог хаягдал устгах төвлөрсөн байгууламжтай, агаарын шүүлтүүртэй, зориулалтын, өндөр хэмд шатаах зуухтай газарт мал амьтны сэг зэм зэрэг бүх эмгэг хог хаягдлыг өндөр хэмд шатааж устгана;

1.3.2. Аюултай хог хаягдал устгах төвлөрсөн байгууламжгүй, зориулалтын, өндөр хэмд шатаах зуухгүй газарт боом болон бусад үр үүсгэдэг нянгийн халдварын сэжигтэй эмгэг хог хаягдлыг энэхүү зааврын 2 дахь хэсэгт заасны дагуу шатааж устгана. Шаталтаас үлдсэн хог хаягдлыг хөрсөнд булна.

1.3.3. Зориулалтын, өндөр хэмд шатаах зуухгүй газарт үр үүсгэдэггүй, гадна орчинд тэсвэрлэх чанар багатай бичил биетнээр үүсгэгдсэн зоонозын халдварын үед эмгэг хог хаягдлыг энэхүү зааврын 3 дахь хэсэгт заасны дагуу булшлах аргаар устгана.

1.4. Мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг устгахын өмнө халдваргүйжүүлэх бодис хийх шаардлагагүй.

1.5. Хог хаягдлыг булшлах ажилчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дагуу халдвараас сэргийлэх зааврыг мөрдөж, шаардлага хангасан хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, ажлын багаж хэрэгсэл (хүрз, жоотуу, лоом гэх мэт)-ээр бүрэн хангагдсан байна.

1.6. Хээрийн нөхцөлд булшлах газрыг усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс гадагш буюу усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд сонгоно.

1.7. Аймаг, орон нутгийн зоонозын өвчин судлалын төвүүд нь зориулалтын шатаах зуухгүй бол байгаль орчны улсын байцаагчтай зөвшилцөн эмгэг хог хаягдлыг булшлах газрыг сонгоно. Тандалт, оношилгоо, судалгаа шинжилгээний явцад үүссэн эмгэг хог хаягдлыг булшлах нүхтэй байна. Булшлах нүх нь Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/173 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Эхэсийн нүхэнд тавигдах шаардлага" хангасан байна.

Хоёр. Шатааж хөрсөнд булшлах арга

2.1. Шатааж хөрсөнд булшлах аргыг хэрэглэх үед мод, түлш, шатамхай бодис (бензин, дизелийн түлш, керосин) зэргийг шаардлагатай хэмжээгээр

бэлтгэсэн байна.

2.2. Шатаах хог хаягдлын хэмжээнээс хамааран тэгш өнцөгт хэлбэрийн нүхийг 1,5-2 метрийн гүн ухаж бэлтгэнэ.

2.3. Ухсан нүхний ёроолд мод өрж тавиад шатаах хог хаягдлаа байрлуулна. Дахин мод өрж дээрээс нь тавиад шатамхай бодисоо хангалттай хэмжээгээр асгана.

2.4. Галтай бамбарыг салхитай талаас холоос шидэж гал өгнө.

2.5. Хог хаягдлыг шатаж дуустал хяналт тавих бөгөөд шатаж дууссаны дараа шороогоор булж дарна.

Гурав. Булшлах арга

3.1. Булшлах газрыг устгах амьтны төрөл зүйл (тарвага 2,5-3 кг, бусад жижиг мэрэгч 0,4-0,5 кг) болон тоо, хэмжээнээс хамааран тэгш өнцөгт хэлбэрийн нүхийг 2,5-3 метрийн гүн ухаж бэлтгэнэ. Шаардлагатай бол дахин шинэ нүх ухаж хог хаягдлыг булшилна.

3.2. Хог хаягдал булшлах газарт үнэр тархах, мэрэгч, шавж нэвтрэхээс сэргийлж хог хаягдал хаях бүрт шороогоор хучна.

Дөрөв. Булшилсан хог хаягдлын битүүмжлэл, хяналт

4.1. Булшлах нүх дүүрэх үед битүүмжилнэ. Битүүмжлэхдээ нүхийг 50 см-ээс доошгүй зузаан хөрсөөр дүүргэж сайтар чигжинэ. Нүхийг шороогоор дүүргэж чигжиж дараа нь газрын гадаргаас дээш 50 см өндөр шороо овоолно.

4.2. Булшилсан газар цагаан дэвсгэр дээр улаан өнгөөр бичсэн "АНХААР" гэсэн анхааруулга тэмдэг байрлуулна.

4.3. Хээрийн нөхцөлд булшилсан хог хаягдлын газрын нэр болон байршлыг газар зүйн байршил тогтоогч багажаар (GPS) тэмдэглэнэ.

4.4. Хог хаягдлыг булшлан устгасан тухай тэмдэглэл хөтөлж анхан шатны бүртгэл маягтад тэмдэглэн тайлагнаж баримтжуулна.

Булшилсан газрын мэдээлэл, хог хаягдал устгасан тухай тэмдэглэлийг харьяа орон нутгийн Байгаль орчны газар болон Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ.